



ЦАГААННУУР СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-04-20 № СНА-2020/04-НА-14
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Цагааннуур сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Цагааннуур сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020571

Дүгнэлт

Цагааннуур сумын Монгол Ардын намын хорооны Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Цагааннуур сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...3... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Цагааннуур сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААНУУР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Цагааннуур сум
2020 он

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААННУУР СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



УРИА: ХҮЧЭЭ НЭГТГЭЭ

1. Нийгмийн бодлогын хүрээнд хэрэгжих ажлууд

- 1.1. ОНӨААТҮГ-ийг бий болгож усан сан ус түгээлт, нийтийн эзэмшлийн зам талбай, нэгдсэн хогийн цэгийн асуудлыг хариуцан ажиллуулна.
- 1.2. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой болон зорилтот бүлгийн айл өрхүүдийг төсөл хөтөлбөрт хамруулах тал дээр хамтран ажиллана.
- 1.3. Өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж ажиллана.
- 1.4. Хашаандаа мод сөөг тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж ажиллана.
- 1.5. Малын үүлдэр угсааг сайжруулах, хээлтүүлгийн чанар хүртээмж, мөн эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулна.
- 1.6. Сум орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутнуудыг дэмжиж ажиллана.
- 1.7. Суманд хүүхэд залуучууд, эмэгтэйчүүдийн талаар баримтлах бодлогыг гаргаж хэрэгжүүлж ажиллана.
- 1.8. Сумын иргэдийн дунд зохиогддог спорт, урлагийн арга хэмжээг сэргээж соёл урлаг, биеийн тамир спортыг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллана.
- 1.9. Цагааннуур сумыг “Газар тариалангийн загвар” сум болгон малчид, тариаланчдын хамтын ажиллагааг сайжруулна.
- 1.10. Орон нутагт МСҮТ-тэй хамтран тариаланч болон шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээг ААН-үүдтэй хамтран шийдвэрлэнэ.
- 1.11. Сумын төвийн хашааны эмх цэгц, өнгө үзэмжийг сайжруулж, эзэнгүй хашаа байшинг цэгцэлж нөхөн олголт хийх ажлыг зохион байгуулна.




- 1.12. Сумын ИТХ, Засаг дарга улирал бүр иргэдтэйгээ уулзаж санал байдлыг хүлээн авч иргэддээ хүрсэн үйлчилгээг үзүүлж ажиллана.
- 1.13. Байгууллага, ААН-ын удирдлагуудын цугларалтыг тогтмол зохион байгуулж, сар бүр байгууллагуудын тайланг тавиулж хэвшинэ.
- 1.14. Хуурчийн булгийн хамгаалалтын хашааг томруулж, булаг шандыг хамгаалах, рашаан булгийг түшиглэн, амралт сувиллын газар байгуулах саналыг дэмжиж ажиллана.
- 1.15. Өмчийн хулгай, малын хулгай, байгаль орчны эсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллана.
- 1.16. Золбин нохой устгах ажлыг жил бүр зохион байгуулж, нохойг бүртгэлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулдаг болгох.
- 1.17. Хүүхэд, залуучуудын дунд оюуны спортыг хөгжүүлэх, интернэт төгөл хүүхэд, залуучуудын өргөөтэй болгох асуудлыг аймгийн ИТХ-ын төлөөлөгч, холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.
- 1.18. Сумын эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, эмнэлгийн өргөтгөлийг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

2. Эдийн засгийн хүрээнд хийгдэх ажлууд

- 2.1. Тийрэг 3-р багийн Хонхорын хэсэгт төвлөрсөн усан сан байгуулж, сангаас шугам татаж байнгын усны эх үүсвэртэй болгоно.
- 2.2. Сумын төвийн 2.4 км хатуу хучилттай замын ажлыг дуусгаж төв замтай холбоно.
- 2.3. Суманд малын гаралтай түүхий эдийг боловсруулах цех бий болгож, уламжлалт аргаар арьс шир, ноос боловсруулах санал санаачилгыг дэмжиж ажиллана
- 2.4. 1-р багийн нутаг дахь Сахилтын давааг засварлахын зэрэгцээ зам давааг засварлаж худаг ус гарган, алслагдсан бэлчээрийг ашиглуулна.
- 2.5. Сумын төвийн төвлөрсөн газруудын ил жорлонг өөрчлөн нийтийн боловсон бие засах газрыг бий болгоно.
- 2.6. Жижиг, дунд өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжиж ажиллана.





- 2.7. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран хууль, журмын дагуу хүнсний ногооны зоорины асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.8. Сумын төвийн айл өрх, барилга байгууламжийг батлагдсан стандартын дагуу хаягжуулна.
- 2.9. Ногоочдод хүнсний ногоо тариалахад туслах тоног төхөөрөмжийн дундын парк бий болгох ажлыг аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
- 2.10. Сургуулийн Б байрны сурагчдын ширээ сандлыг шинэчилж, хичээлийн байрын өргөтгөлийг улсын төсөвт суулгах ажлыг уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.11. Байгалийн ухааны кабинетуудыг багаж, тоног төхөөрөмжүүдээр хангана.
- 2.12. Соёлын төвийн техник, тоног төхөөрөмж, тайзыг шинэчилж, урлагийн хувцасны нөөцийг нэмэгдүүлнэ.
- 2.13. Хөрс хамгаалах, хөрсийн үржил шимийг хамгаалан сайжруулах, үндсэн болон нэмэлт бордоог хэрэглэх үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 2.14. 2, 3-р багийн нутаг дэвсгэрт зам тавьж гэрэлтүүлэг нэмнэ.
- 2.15. 2-р багт хүүхдийн тоглоомын талбай байгуулна.
- 2.16. Сумын 100-н жилийн ойг тохиолдуулан Атарчидын өндөрлөг байгуулна.
- 2.17. Цагааннуур самбарын тохижилтыг сайжруулж, Зүүн гүвээнд угталт, үдэлтийн алжаал тайлах газартай болно.
- 2.18. Шүрэнгийн голын гүүрийг засварлана.
- 2.19. Тариан талбайг хашсан хашааны эзэмшил, хамгаалалтыг сайжруулж шинээр талбайг үргэлжлүүлэн хашаажуулах зорилт тавин ажиллана.

ЦАГААННУУР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

